



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/523

Арвайхээр

### Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.4.а, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.2.5 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Арвайхээр суманд баригдах дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээний зураг, төслийн дагуу төв бараан зах дахь инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын зардалд 70,000,000 (далан сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

3.Дээрх хөтөлбөр арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (З.Балданням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101110